



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн
14 дүгээр тогтоолын хавсралт

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН
ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ**
/Шинэчилсэн найруулга/

ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл	2
Хоёр.Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээдэд тавигдах шаардлага ..	2
Гурав.Гишүүнээр элсүүлэх, татгалзах тухай.....	3
Дөрөв.Гишүүний үйлчилгээний хөлс, хөнгөлөлт, чөлөөлт	4
Тав.Биржийн болон гишүүний эрх, үүрэг	4
Долоо.Хариуцлага.....	6
Найм.Бусад.....	7
“Гишүүнчлэлийн журам”-ын <u>Хавсралт 1</u>	8
“Гишүүнчлэлийн журам”-ын <u>Хавсралт 2</u>	11
“Гишүүнчлэлийн журам”-ын <u>Хавсралт 3</u>	20
“Гишүүнчлэлийн журам”-ын <u>Хавсралт 4</u>	22
“Гишүүнчлэлийн журам”-ын <u>Хавсралт 5</u>	23
“Гишүүнчлэлийн журам”-ын <u>Хавсралт 6</u>	24

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн
14 дүгээр тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ийн “Гишүүнчлэлийн журам”-аар үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийг биржид гишүүнээр элсэх өргөдлийг хүлээн авах, гишүүнээр элсүүлэх, элсүүлэхээс татгалзах, хяналт тавих, хариуцлага ногдуулах, үүргийн хэрэгжилтийг дүгнэн олон нийтэд мэдээлэх, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах, сэргээх, хасахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гишүүн үнэт цаасны компани (цаашид “Гишүүн” гэх) нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх), Биржийн дүрэм, журам, заавар болон холбогдох бусад хууль тогтоомж, шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөнө.
- 1.3. Журмыг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, ил тод, бодитой, үнэн зөв, шуурхай байх зарчмуудыг баримтална.

Хоёр. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээдэд тавигдах шаардлага

- 2.1. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1. үйл ажиллагаагаа тогтвортой, тасралтгүй явуулах дунд хугацааны бизнес төлөвлөгөөтэй байх;
 - 2.1.2. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Хорооноос тогтоосон хэмжээг хангаж байх;
 - 2.1.3. энэхүү журмын 2.1.2-д заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний гурваас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах сан байгуулсан байх;
 - 2.1.4. энэхүү журамд заасан үйлчилгээний хөлсийг төлсөн байх;
 - 2.1.5. хөрөнгийн зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомжтой бүрэн танилцсан, тэдгээр хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа шударгаар, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхийг баталсан баталгааг компанийг төлөөлж Хавсралт 2-ийн НЭГ-д заасны дагуу компанийн эрх бүхий албан тушаалтан, хавсралт 2-ийн ХОЁР.А-д заасны дагуу ажилтан тус бүрээр гаргасан байх;
 - 2.1.6. харилцагчдын үнэт цаасны бүртгэл тооцоо, арилжаа, төлбөр тооцооны мэдээллийг түргэн, шуурхай боловсруулж гаргах программ хангамжтай байх;
 - 2.1.7. ажлын байр, техник тоног төхөөрөмжөөр хангагдаж, үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
 - 2.1.8. мэргэжилтнүүд нь үнэт цаасны зах зээлд мэргэшлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхтэй байх;

- 2.1.9. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээд нь дараах журмуудыг боловсруулсан байна. Үүнд:
 - 2.1.9.1. Брокерийн/Дилерийн/Андеррайтерийн үйл ажиллагааны журам;
 - 2.1.9.2. Дотоод хяналтын үйл ажиллагааны журам;
 - 2.1.9.3. Харилцагчдыг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааны журам;
 - 2.1.9.4. Харилцагч, хөрөнгө оруулагчдад мэдээлэл түгээх үйл ажиллагааны журам;
 - 2.1.9.5. Зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх дотоод журам;
 - 2.1.9.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх журам;
 - 2.1.9.7. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам.
- 2.2. Бирж нь Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн хуулийн этгээдийг энэ журмын 2.1-т заасан шаардлагыг хангасан тухай дүгнэлтийг баримт бичиг бүрэн хангагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

Гурав. Гишүүнээр элсүүлэх, татгалзах тухай

Гишүүнээр элсүүлэх

- 3.1. Гишүүнээр элсэх өргөдөл гаргагч нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
 - 3.1.1. Гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч нь энэхүү журмын хавсралт 2-т заасан өргөдлийн маягтыг бөглөж, холбогдох бичиг баримтуудыг баримт бичгийн стандартын дагуу боловсруулан эмхлэн товьёглож гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан хавсарган ирүүлнэ.
 - 3.1.2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гишүүнээр бүртгүүлэхдээ холбогдох бичиг баримтуудыг Монгол хэл дээр үйлдэн баталгаажуулж ирүүлнэ.
 - 3.1.3. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.
 - 3.1.4. Энэхүү журамд заасан элсэлтийн хөлсийг төлсөн баримтыг хавсаргасан байна.
- 3.2. Бирж нь бүрэн хангасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.
- 3.3. Нэмэлт материал, тодруулга ирүүлэх шаардлагатай тохиолдолд энэхүү журмын 3.2-д заасан хугацааг нэг удаа ажлын 10 өдөр хүртэл хугацаагаар сунгаж болно.
- 3.4. Өргөдлийг хүлээн авч хянах явцад ирүүлсэн бичиг баримтад нэмэлт өөрчлөлт орсон бол өргөдөл гаргагч нь энэ тухайгаа ажлын 3 өдрийн дотор Биржид мэдэгдэнэ.
- 3.5. Өргөдөл гаргагчийн гишүүнээр элсүүлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гарч, Биржтэй “Гишүүнчлэлийн гэрээ” (цаашид “гэрээ” гэх) байгуулснаар гишүүнээр элссэнд тооцно.

Гишүүнээр элсүүлэхээс татгалзах

- 3.6. Дараах тохиолдолд биржийн гишүүнээр элсүүлэхээс татгалзана. Үүнд:
 - 3.6.1.1. биржээс дутуу баримт бичгийг хугацаа тогтоон шаардсан боловч тухайн хугацаа дууссан, худал мэдээлсэн, төөрөгдүүлсэн, хоорондоо зөрүүтэй мэдээлэл агуулсан;

- 3.6.1.2. биржээс өргөдөлтэй холбогдуулан тогтоосон хугацаанд шаардсан мэдээллийг бүрэн ирүүлээгүй;
 - 3.6.1.3. гишүүнээс хасагдсан компани нь дахин гишүүнээр элсэх тухай өргөдлийг 6 сарын дотор биржид гаргасан;
 - 3.6.1.4. өргөдөл гаргагч гишүүнээр элсэж, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх нь түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компанийн үйл ажиллагаатай харшилж, сонирхлын зөрчил үүсгэнэ гэж үзсэн;
 - 3.6.1.5. хуурамч бичиг баримт бүрдүүлсэн гэх үндэслэлээр гишүүнээр элсүүлэхээс татгалзсан компани нь 1 жилийн дотор дахин гишүүнээр элсэх хүсэлт гаргасан.
- 3.7. Биржийн Гүйцэтгэх захирал нь гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэрийг тайлбарын хамт өргөдөл гаргагч этгээдэд бичгээр хүргүүлнэ.

Дөрөв. Гишүүний үйлчилгээний хөлс, хөнгөлөлт, чөлөөлт

- 4.1. Гишүүн нь энэ журмын Хавсралт 4-т заасны дагуу үйлчилгээний хөлсийг төлнө.
- 4.2. Гишүүн нь Бирж дээр хийгдсэн тухайн жилийн нийт үнэт цаасны арилжааны үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх гүйлгээг дангаар хийсэн бол дараа жилийн гишүүнчлэлийн жилийн үйлчилгээний хөлснөөс 10 хувиар хөнгөлнө.
- 4.3. Гишүүн нь Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн бөгөөд санхүүгийн жилийн хугацаанд үүргийн хэрэгжилтийг 2 улирал дараалан хангасан тохиолдолд жилийн үйлчилгээний хөлснөөс 10 хувиар хөнгөлнө.
- 4.4. Биржид гишүүнээр элсүүлэх шийдвэр гарсан өдрөөс хойш Гишүүн нь гишүүний жилийн үйлчилгээний хөлснөөс нэг жилийн хугацаанд чөлөөлөгднө.
- 4.5. Гишүүний эрхийг түр хязгаарласан болон түдгэлзүүлсэн нь гишүүнчлэлийн хөлс төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 4.6. Гишүүнээс хасагдсан тохиолдолд гишүүнчлэлийн элсэлтийн болон жилийн хөлсийг буцаан олгохгүй.

Тав. Биржийн болон гишүүний эрх, үүрэг

- 5.1. Бирж дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 5.1.1. гишүүний үйл ажиллагаанд хяналт тавьж, журам, заавар гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор шалгалт хийж, холбогдох хариуцлага ногдуулах;
 - 5.1.2. энэхүү журам болон гэрээнд заасан үйлчилгээний хөлс, холбогдох бусад төлбөрийг тогтоосон хугацаанд төлөхийг шаардах;
 - 5.1.3. гишүүний санхүүгийн тайлан, мэдээ, удирдлага, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, ажилтны талаарх мэдээллийг шаардах;
 - 5.1.4. гишүүний гаргасан зөрчил нь хөрөнгө оруулагч, харилцагчдад хохирол учруулсан тухай нэн даруй Хороонд мэдэгдэж холбогдох арга хэмжээг авах;
 - 5.1.5. гишүүн нь баримт материал хуурамчаар бүрдүүлсэн байж болзошгүй тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгдэх;
 - 5.1.6. гэрээ болон холбогдох журмаар хүлээсэн үүргийн биелэлт болон программ хангамжийн хэвийн, найдвартай ажиллагааг хагас жил тутам дүгнэн, дүнг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх.

- 5.2. Бирж дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 5.2.1. өдөр тутмын арилжааг зохион байгуулах, арилжааны программын хэвийн ажиллагааг хангаж, мэдээллийн нууцлалыг хадгалах;
 - 5.2.2. гишүүдээс гаргасан санал, хүсэлт, гомдлыг тухай бүр шийдвэрлэж хариу өгөх;
 - 5.2.3. гишүүдийн сар бүрийн үнэт цаасны арилжааны тайлан мэдээг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх;
 - 5.2.4. энэхүү журам болон гэрээнд заасан бусад.
- 5.3. Гишүүн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
- 5.3.1. үнэт цаасны арилжаа, үнэ ханшийн болон зах зээлийн холбогдолтой олон нийтэд тараагдах мэдээ, мэдээллийг гаргуулан авах;
 - 5.3.2. биржид санал, хүсэлт гаргах, тогтоосон хугацаанд үндэслэл бүхий хариу авах, асуудлыг харилцан зөвшилцэж, хамтран шийдвэрлэх;
 - 5.3.3. биржийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд хороонд гомдол гаргах;
 - 5.3.4. энэхүү журам болон гэрээнд заасан бусад.
- 5.4. Гишүүн нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 5.4.1. гишүүн нь жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан гэрээгээ дүгнүүлэх, сунгуулах;
 - 5.4.2. энэхүү журам болон гэрээнд заасан төлбөрийг цаг тухайд нь тогтмол төлөх;
 - 5.4.3. гишүүн нь мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах;
 - 5.4.4. “Монголын хөрөнгийн биржийн гишүүдийн дагаж мөрдөх ёс зүйн дүрэм”-ийг баримтлах;
 - 5.4.5. энэхүү журам болон гэрээнд заасан бусад.

Зургаа.Ил тод мэдээлэх

- 6.1. Гишүүн нь өөрийн компанийн албан ёсны цахим хуудсыг тогтмол ажиллуулж дараах мэдээ мэдээллийг өөрийн болон биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлнэ. Үүнд:
- 6.1.1. хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан;
 - 6.1.2. хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, ажилтны мэдээлэл;
 - 6.1.3. компанийн хаяг, байршил, холбоо барих утасны дугаар, и-мэйл хаяг.
- 6.2. Гишүүн нь Биржид дараах мэдээллийг дор заасан хугацаанд ирүүлнэ. Үүнд:
- 6.2.1. нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж, аудитын дүгнэлтийн хамт дараа оны 04 дүгээр сарын 30-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны дотор;
 - 6.2.2. дотоод мэдээлэл эзэмшигчийн мэдээлэлд өөрчлөлт орсноос хойш ажлын 3 өдрийн дотор;
 - 6.2.3. гишүүн нь энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан баримт бичигт аливаа өөрчлөлт орсноос хойш ажлын 3 өдрийн дотор;
 - 6.2.4. компанийн дүрэмд өөрчлөлт орсноос хойш ажлын 3 өдрийн дотор;
 - 6.2.5. хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага, ажилтны мэдээлэлд өөрчлөлт орсноос хойш ажлын 10 өдрийн дотор;
 - 6.2.6. компанийн хаяг, байршил өөрчлөлт орсноос хойш ажлын 3 өдрийн дотор;
 - 6.2.7. анхан шатны баримт бүрдүүлэлтийн баталгааг Хавсралт-б-д заасны дагуу улирал тутам.

Долоо.Хариуцлага

- 7.1. Бирж нь гишүүний үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийн төрлөөс шалтгаалан гишүүнд дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 7.1.1. Дараах тохиолдолд сануулах арга хэмжээ авна. Үүнд:
- 7.1.1.1. энэхүү журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон хугацаандаа биелүүлээгүй;
- 7.1.1.2. “Монголын хөрөнгийн биржийн гишүүдийн дагаж мөрдөх ёс зүйн дүрэм”-ийг зөрчсөн.
- 7.1.2. Дараах тохиолдолд үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээ авна. Үүнд:
- 7.1.2.1. Хороо болон Хорооны улсын байцаагчийн шийдвэр гарсан;
- 7.1.2.2. энэхүү журам болон гэрээнд заасан төлбөр, хөлсийг хугацаанд нь төлж барагдуулалгүй 30 хоног болсон;
- 7.1.2.3. арилжааны дэнчин байршуулах, эсвэл төлбөр гүйцэтгэх үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тухай арилжааны төлбөр тооцооны байгууллагаас удаа дараа мэдэгдсэн;
- 7.1.2.4. сануулах арга хэмжээний хүрээнд биржээс өгсөн үүрэг, даалгаврыг заасан хугацаанд биелүүлээгүй;
- 7.1.2.5. олон нийтийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаа, хуурамч мэдээлэл тараасан болохыг төрийн эрх бүхий байгууллага тогтоосон;
- 7.1.2.6. хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироосон, хохироож болзошгүй үйлдэл, эс үйлдэл гаргасан.
- 7.1.3. Дараах тохиолдолд гишүүнээс хасна. Үүнд:
- 7.1.3.1. гишүүнээс хасгдах хүсэлтээ өөрөө гаргасан;
- 7.1.3.2. гишүүний эрхийг түдгэлзүүлснээс хойш 3 сарын хугацаанд эрхээ сэргээлгэх талаар арга хэмжээ аваагүй;
- 7.1.3.3. Хорооноос үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон;
- 7.1.3.4. гишүүн нь төлбөрийн чадваргүй болсон эсхүл татан буугдсан нь тогтоогдсон;
- 7.1.3.5. энэ журам болон гэрээнд заасан аливаа төлбөр, хураамж, хөлсийг тогтоосон хугацаанд төлж барагдуулалгүй 6 сар болсон;
- 7.1.3.6. биржийн болон дотоодын хөрөнгийн зах зээлийн нэр хүндэд харшлах үйл ажиллагаа, үйлдэл хийсэн нь тогтоогдсон;
- 7.1.3.7. гишүүнээр элсэхдээ хуурамч баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 7.1.3.8. энэхүү журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн;
- 7.1.3.9. тухайн санхүүгийн жилийн хугацаанд удаа дараа үнэт цаасны арилжаанд оролцох эрхээ түдгэлзүүлсэн;
- 7.1.3.10. үүргийн хэрэгжилтээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн.
- 7.2. Дараах тохиолдолд гишүүний эрхийг сэргээнэ. Үүнд:
- 7.2.1. гишүүн гаргасан зөрчлөө арилгасан тухайгаа мэдэгдсэн эсхүл биржээс уг зөрчлийг арилсан гэж тогтоосон;
- 7.2.2. Хорооноос гишүүний тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- 7.2.3. зохицуулах эрх бүхий байгууллага, шүүх, хяналтын байгууллагаас гишүүнд авсан арга хэмжээг үндэслэлгүй гэж үзэн Хороо болон Биржийн шийдвэрийг хүчингүй болгосон;
- 7.2.4. хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл.

- 7.3. Энэ журамд заасан хариуцлагын арга хэмжээ авах эсэхийг гишүүн хариуцсан нэгжийн саналыг үндэслэн ТУЗ болон Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.
- 7.4. Бирж нь Гишүүний эрхийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах тохиолдолд Хороо, үнэт цаасны төлбөр, тооцооны байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон гишүүнд холбогдох шийдвэрийг нэн даруй мэдэгдэнэ.

Найм.Бусад

- 8.1. Биржийн хяналт шалгалт хариуцсан нэгж энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина.
- 8.2. Энэхүү журмыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тэдгээрийн хүчин төгөлдөр болох хугацаа, дагаж мөрдөх журмын талаарх Биржийн ТУЗ-ийн шийдвэрийг Хороо батlamжилснаар хүчин төгөлдөр болно.
- 8.3. Гишүүн нь Биржээс гаргасан шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор тус шийдвэртэй холбоотой гомдлыг Хороонд гаргана.

---о0о---

“Гишүүнчлэлийн журам”-ын
Хавсралт 1

Батлав. “Монголын хөрөнгийн бирж”
ХК-ийн Гүйцэтгэх захирал

Батлав. ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

ГИШҮҮНЧЛЭЛИЙН ГЭРЭЭ

20... оны ... сарын... -ны өдөр

№...

Улаанбаатар хот

Нэг талаас “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “Бирж” гэх), түүнийг төлөөлөн , нөгөө талаас Биржийн гишүүн үнэт цаасны компани ХХК (цаашид “гишүүн” гэх) (хамтад нь “талууд” гэх) нар дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Бирж нь үнэт цаасны компанийг гишүүнээр элсүүлж, үнэт цаасны зах зээлд арилжаа явуулах нөхцөл, дэд бүтцээр хангах, Гишүүн нь харилцан тохиролцсон гишүүнчлэлийн төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Талууд үйл ажиллагаандаа Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) болон Биржээс баталсан журам, заавар болон энэхүү гэрээг дагаж мөрдөнө.
- 1.3. Холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд эсхүл талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 1.4. Талууд хамтран ажиллахдаа бизнесийн болон ажил хэргийн нэр хүндийг гуравдагч этгээдийн өмнө харилцан хамгаалж, хууль ёсны эрх ашгийг хүндэтгэнэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Энэхүү гэрээг 20... оны ... сарын ...-ны өдрөөс 20... оны ... сарын ...-ны өдрийг хүртэл нэг жилийн хугацаатай байгуулав.
- 2.2. Гэрээний үүргийн биелэлтийг дүгнэн гэрээний хугацааг сунгана.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Бирж дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 3.1.1. гишүүний үйл ажиллагаанд хяналт тавьж, журам, заавар гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор шалгалт хийж, холбогдох хариуцлага ногдуулах;
 - 3.1.2. энэхүү журам болон гэрээнд заасан үйлчилгээний хөлс, холбогдох бусад төлбөрийг тогтоосон хугацаанд төлөхийг шаардах;
 - 3.1.3. гишүүний санхүүгийн тайлан, мэдээ, удирдлага, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүн, ажилтны талаарх мэдээллийг шаардах;
 - 3.1.4. гишүүний гаргасан зөрчил нь хөрөнгө оруулагч, харилцагчдад хохирол учруулсан тухай нэн даруй Хороонд мэдэгдэж холбогдох арга хэмжээг авах;
 - 3.1.5. гэрээ болон холбогдох журмаар хүлээсэн үүргийн биелэлт болон программ хангамжийн хэвийн, найдвартай ажиллагааг хагас жил тутам дүгнэн, дүнг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх.
- 3.2. Биржийн дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.2.1. өдөр тутмын арилжааг зохион байгуулах, арилжааны программын хэвийн ажиллагааг хангаж, мэдээллийн нууцлалыг хадгалах;
- 3.2.2. гишүүнээс гаргасан санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэж хариу өгөх;
- 3.2.3. гишүүдийн сар бүрийн үнэт цаасны арилжааны тайлан мэдээг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх;
- 3.2.4. гишүүний гаргасан хүсэлтийн дагуу түүний техник хангамж, программ хангамжийг биржийн сүлжээнд анх холбоход шаардлагатай техникийн болон үйл ажиллагааны туслалцааг үнэ төлбөргүйгээр үзүүлэх, арилжааны системийг ашиглах заавар, зөвлөгөө өгөх;
- 3.2.5. гишүүний арилжаанд оролцох, мэдээлэл авах ижил нөхцөлөөр хангах;
- 3.3. Гишүүн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
- 3.3.1. үнэт цаасны арилжаа, үнэ ханшийн болон зах зээлийн холбогдолтой олон нийтэд тараагдах мэдээ, мэдээллийг авах;
- 3.3.2. биржид санал, хүсэлт гаргах, тогтоосон хугацаанд үндэслэл бүхий хариу авах, асуудлыг хамтран шийдвэрлэх, харилцан зөвшилцэх;
- 3.3.3. үнэт цаасны зах зээлийн сайжруулах чиглэлээр хамтран ажиллах;
- 3.3.4. биржийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд хороонд гомдол гаргах;
- 3.3.5. энэхүү журам болон гэрээнд заасан бусад.
- 3.4. Гишүүн нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 3.4.1. арилжааны системд Биржийн “Гишүүнчлэлийн журам”-д заасан шаардлага хангасан техник хэрэгсэл ашиглах ба Арилжааны системд нэвтрэх код, программ хангамжийн тохиргоо, түүний нууцлал, хамгаалалтыг хангаж, зориулалтын дагуу ашиглах, үүнтэй холбоотойгоор гарах аливаа зардлыг хариуцах;
- 3.4.2. гишүүнчлэлийн хөлсийг улирал бүрийн эхний 10 хоногийн дотор, арилжааны системд нэвтрэх эрхийн төлбөрийг улирал бүрийн эхний 10 хоногийн дотор төлөх;
- 3.4.3. гишүүний ажлын байрны байршил, хаяг тодорхой байх, олон нийтэд тодорхой бус нөхцөлд ойролцоо гарц гармын дагуу тэмдэг тавих, шилжилт хөдөлгөөнийг тухай бүр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, харилцагчдыг хүлээн авах цагийн хуваарь гарган тогтмол мөрдөж ажиллах;
- 3.4.4. холбогдох журмын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, түүний үнэн зөвийг хариуцах, харилцагчийн утсаар өгсөн захиалгыг дуу хоолойны болон дүрст бичлэгээр баталгаажуулж, бичлэгийг компьютерын санамжид файл хэлбэрээр хадгалах, цахим хэлбэрээр ирүүлсэн захиалгыг захиалгын гэрээнд хавсаргах, цахим хэлбэрээр захиалга авах тусгай программ хэрэглэх, хяналт шалгалтын ажиллагааны явцад шаардлагатай тохиолдолд анхан шатны баримт, холбогдох бусад баримт мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэх;
- 3.4.5. гишүүн нь өөрийн цахим хуудсаар дамжуулан харилцагчдыг шаардлагатай мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллах.

ДӨРӨВ. ХАРИЛЦАА ХОЛБОО

- 4.1. Бирж нь Гишүүнд мэдээллийг Биржийн цахим хуудас, цахим шуудан, албан бичгээр хүргүүлж болно.
- 4.2. Гишүүн нь Биржид хүргүүлэх аливаа мэдээллийг цахимаар эсхүл бичгээр хүргүүлнэ.
- 4.3. Энэхүү гэрээний 4.1-д заасны дагуу Биржээс мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн тохиолдолд ажлын 3 өдөрт, цахим шуудангаар илгээсэн болон цахим хуудаст нийтэлсэн тохиолдолд тухайн өдөр гишүүнийг танилцсанд тооцно.

ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 5.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай тал хариуцан барагдуулна.

- 5.2. Гишүүн нь энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Биржийн зүгээс “Гишүүнчлэлийн журам”-ын 7 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 5.3. Гишүүн нь гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцно.
- 5.4. Гишүүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бирж хариуцахгүй.
- 5.5. Цахилгаан, сүлжээний дэд бүтэц (үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас хамаарах) болон Биржийн үйл ажиллагаанаас үл хамаарах бусад гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөлийн улмаас үүссэн аливаа хохирлыг Бирж хариуцахгүй.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1. Гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2. Талуудын хүсэлтээр харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 6.3. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцэж шийдвэрлэх ба 30 хоногийн дотор тодорхой шийдвэрт хүрч чадаагүй тохиолдолд шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг
төлөөлөн:

“.....” ХХК-ийг төлөөлөн:

.....

.....

/..... /

/..... /

ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ:

20..... оны сарын өдрийг хүртэл сунгав.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг
төлөөлөн:

“.....” ХХК-ийг төлөөлөн:

.....

.....

/..... /

/..... /

---оо---

“Гишүүнчлэлийн журам”-ын
Хавсралт 2

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХЭЭР
ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ КОМПАНИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ**

НЭГ.КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

1 Компанийн ерөнхий мэдээлэл		
1.1	Компанийн нэр	
1.2	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	
1.3	Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан огноо	
1.4	Регистрийн дугаар	
1.5	Компанийн харьялал	
1.6	Хувьцаат капиталын дүн	
1.7	СЗХ-ны тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөл авсан огноо
	Брокер	
	Дилер	
	Андеррайтер	
	Хөрөнгө оруулалтын зөвлөх	
	Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ	
2 Үйлчилгээний нөхцөл		
2.1	Данс нээх хураамж	
2.2	Арилжааны шимтгэл	Хувьцаа ЗГ-ийн бонд Компанийн бонд
2.3	Харилцагч банк	Нэр
		Дансны дугаар
2.4	Төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны нэр	
2.5	Ажиллах цагийн хуваарь	
3 Хаяг, байршил		
3.1	Ажлын байрны талаарх мэдээлэл	<input type="checkbox"/> Өөрийн <input type="checkbox"/> Түрээс
3.2	Байршил	Төв: Салбар:.....

3.3	Веб сайт			
3.4	И-мэйл хаяг			
3.5	Ажлын утас, факс			
4	Үүсгэн байгуулагч			
№	Овог, нэр	Оруулсан хөрөнгийн		Ажил эрхлэлтийн байдал
		Үнийн дүн	Хувь	
5	Төлөөлөн удирдах зөвлөл			
№	Овог, нэр	Албан тушаал	Ажил эрхлэлт	
1				
2				
3				
4				
5				
6	Санхүүгийн үзүүлэлт /..... оны сарын –ны байдлаар/			
№	Үзүүлэлт	Актив	Пассив	
1	Нийт хөрөнгө			
	Эргэлтийн хөрөнгө			
	Эргэлтийн бус хөрөнгө			
2	Өр төлбөр, Эзэмшигчийн өмчийн дүн			
	Өр төлбөр			
	Эзэмшигчийн өмч			
3	Тэнцэл			
4	Аудит хийсэн компани	Нэр:	Хаяг:	
7	Санхүүгийн төлөвлөгөө			
№	Үзүүлэлт	20... он	20... он	20... он
1	Нийт гүйлгээний дүн			
	Хувьцаа			
	Засгийн газрын бонд			
	Компанийн бонд			
2	Нийт орлого			
	1.Брокерийн үйл ажиллагаанаас			
	2. Дилерийн үйл ажиллагаанаас			

	3.Андеррайтерийн үйл ажиллагаанаас			
	4. Бусад орлого			
3	Нийт зардал			
4	Цэвэр ашиг			
8	Ажиллагсдын мэдээлэл /салбарыг оролцуулна/			
№	Ажилтнуудын овог, нэр	Албан тушаал	Ажилд орсон огноо	ҮЦЗЗ-д мэргэжлийн ажил, үйлчилгээ эрхлэх үнэмлэхийн дугаар
1				
2				
3				
4				
5				
6				
9	Бусад мэдээлэл			Тийм
1	Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл толгой компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчиж байсан, сүүлийн 5 жилийн хугацаанд зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болж, гишүүний эрх нь цуцлагдсан үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан эсэх			
2	Өргөдөл гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, толгой компани дампуурсан, төлбөрийн чадваргүйд тооцогдож байсан эсэх			
3	Өргөдөл гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсхүл толгой компани нь эдийн засгийн гэмт хэрэгт холбогдон буруутай нь тогтоогдсон эсхүл сэжиглэгдэн шалгагдаж байгаа эсэх			
*“Тийм” хариултын тайлбарыг хавсаргана уу.				
10	Бүрдүүлэх материалын жагсаалт			

Дараах баримт бичгийг энэхүү өргөдлийн маягтын хамт ирүүлнэ. Үүнд:


1. Биржид гишүүнээр элсэхийг хүссэн албан бичиг;
2. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх байгууллага байгуулах тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр;
3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
4. Компанийн дүрмийн баталгаажсан хуулбар;
5. Бизнес төлөвлөгөө /3-5 жил/;
6. Санхүүгийн аудитлагдсан тайлан баланс, шинээр байгуулагдсан компани бол эхлэлтийн баланс
7. Харилцах дансны баталгаажсан хуулга /сүүлийн 3 сараас доошгүй хугацааны дансны хуулга/
8. Харилцагч банкны дансны үлдэгдэлтэй тодорхойлолт, /СЗХ-оос тусгай зөвшөөрөл авсны дараа Биржид гишүүнээр элсэх тохиолдолд/
9. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, албан тушаалтнуудын татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт;
10. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, албан тушаалтнуудын өр төлбөртэй эсэх талаарх ШШГЕГ-ын тодорхойлолт;
11. Албан тушаалтны мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхийн хуулбар, их, дээд сургуулийн дипломын хуулбар, “Гишүүнчлэлийн журам”-ын хавсралтаар баталсан дэлгэрэнгүй анкет, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх эрхийн гэрчилгээний хуулбар;
12. Тоног төхөөрөмж, эд хөрөнгийн жагсаалт, журамд заасан шаардлага хангасан эсэхийг тодорхойлох баримт;
13. Түрээсийн гэрээ эсвэл үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ;
14. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны журмын дагуу дотооддоо мөрдөхөөр гаргасан журам, зааврууд;
15. Арилжааны төлбөр, тооцоо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай байгуулсан гэрээний хуулбар;
16. Өргөдлийн хураамж төлсөн баримт;
17. Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар, СЗХ-ны тогтоолын хуулбар.

Албан ёсны баримт бичгийг заавал нотариатаар баталгаажуулах
шаардлагатай.

Энэхүү жагсаалтын 15-17 дугаарт заасан баримт бичгийг
СЗХ-ноос зохих тусгай зөвшөөрөл авсны дараа ирүүлнэ

11 Батламж

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч “.....” компани нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-д ирүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ба цаашид Монгол Улсын хууль тогтоомж, үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журам, заавар, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.



Тамга

Захирал

/ Гарын үсэг/

20... оны ... сарын ... -ний өдөр

---оо---

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1	Ерөнхий мэдээлэл					
1.1	Овог					
1.2	Нэр					
1.3	Хүйс /сонгох/	Эрэгтэй:	Эмэгтэй:	Цээж зураг 3x4 см		
1.4	Төрсөн он, сар, өдөр					
1.5	Иргэний харьяалал					
1.6	Регистрийн дугаар					
1.7	И-мэйл хаяг:					
1.8	Гэрийн хаяг					
1.9	Холбоо барих утас:	1.	2.			
2	Боловсрол					
2.1	Төгссөн сургуулийн нэр	Хаана	Элссэн он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	
2.2	Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх	Дугаар:		Авсан огноо:	Дуусах огноо:	
3	<i>Aжлын туршилага /Одоо эрхэлж буй ажлыг оролцуулан бичнэ/</i>					
	Хаана, ямар албан байгууллагад	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Ажлаас гарсан шалтгаан	
4	<i>Гэр бүлийн байдал</i>					
	Таны юу болов	Овог нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар	Одоо эрхэлж буй ажил	
5	Батламж					

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч
“.....” компанийн /албан тушаал,
хөрөнгө оруулагч/ овогтой
..... нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-д ирүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ба цаашид Монгол Улсын хууль тогтоомж, үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Сангхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журам, заавар, гэрээтэй бүрэн танилцсан бөгөөд цаашид хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.

Батламжилсан:

/гарын үсэг/

БҮРТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН: _____ / Гарын үсэг/ БҮРТГЭЛТЭЙ

ТАНИЛЦСАН: _____ /Компанийн захирал/

20 ... оны сарын өдөр

---о0о---

ХОЁР.А) БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1	Ерөнхий мэдээлэл						
1.1	Овог						
1.2	Нэр						
1.3	Хүйс /сонгох/		Эрэгтэй:	Эмэгтэй:	<div style="border: 1px solid black; padding: 5px; width: fit-content; margin: auto;"> Цээж зураг 3x4 см </div>		
1.4	Төрсөн он, сар, өдөр						
1.5	Иргэний харьяалал						
1.6	Регистрийн дугаар						
1.7	И-мэйл хаяг:						
1.8	Гэрийн хаяг						
1.9	Холбоо барих утас:		1.	2.			
2	Боловсрол						
2.1	Төгссөн сургуулийн нэр		Хаана	Элссэн он	Tөгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Dиплом, Гэрчилгээний дугаар
2.2	Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх		Дугаар:		Авсан огноо:	Дуусах огноо:	
3	Ажлын туршилага /Одоо эрхэлж буй ажлыг оролцуулан бичнэ/						
	Хаана, ямар албан тушаал		Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Ажлаас гарсан шалтгаан	
4	Гэр бүлийн байдал						
	Таны юу болох	Овог нэр		Регистрийн дугаар	Tөрсөн газар	Oдоо эрхэлж буй ажил	
5	Батламж						

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсэхээр өргөдөл гаргагч
“.....” компанийн /албан тушаал,
хөрөнгө оруулагч/ овогтой
ны “Монголын хөрөнгийн бирж” ХК-д ирүүлсэн материалын үнэн зэвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ба цаашид Монгол Улсын хууль тогтоомж, үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журам, заавар, гэрээтэй бүрэн танилцсан бөгөөд цаашид хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.

Батламжилсан:

/гарын үсэг/

БҮРТГЭЛИЙГ ҮНЭН ЗӨВ ГАРГАСАН: _____ / Гарын үсэг/ БҮРТГЭЛТЭЙ

ТАНИЛЦСАН: _____ /Компанийн захирал/

20 ... оны сарын өдөр

---оо---

**ХОЁР.Б) ГИШҮҮН КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ТОДОРХОЙЛОЛТ**

Д/д	Компанийн ерөнхий мэдээлэл		
1	Компанийн нэр		
2	Байгуулагдсан огноо		
3	Регистрийн дугаар		
4	Компанийн харьяалал		
5	Үйл ажиллагааны чиглэл		
6	Хувьцаат капиталын дүн		
7	Гишүүн компани дахь эзэмшлийн мэдээлэл	Оруулсан хөрөнгийн үнийн дүн:	Оруулсан хөрөнгийн хувь:
8	Удирдлагын нэр		
9	Компанийн хаяг		
10	Веб сайт		
11	И-мэйл хаяг		
12	Холбоо барих утас, факс		

---оо---

АРИЛЖААНЫ СИСТЕМИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн компани нь арилжааны системд холбогдохдоо дараах техникийн шаардлагыг хангасан байна. Үүнд:

Техникийн шаардлага:

Биржийн холбогдох арилжааны программыг суулгахад шаардлагатай техникийн шаардлага;

Холболтын шаардлага:

- Программ хангамжийн түвшин дэх VPN туннел; /Холболтын зурвасын өргөн нь 2 Mbps болон түүнээс доошгүй байх шаардлагатай/
- Техник хангамжийн түвшин дэх VPN туннел; /Холболтын зурвасын өргөн нь 3 Mbps болон түүнээс доошгүй байх, IPSec дэмждэг сүлжээний төхөөрөмж байх шаардлагатай/
- Шууд холболт; /Холболтын зурвасын өргөн нь 1 Mbps болон түүнээс доошгүй байх, IPSec дэмждэг сүлжээний төхөөрөмж болон холболтын шилэн кабел байх шаардлагатай/

Компьютерын шаардлага:

- Intel Dual Core болон түүнээс дээш загварын CPU;
- 512 Mb болон түүнээс дээш хэмжээтэй шуурхай санах ой; (трэйдэрийн профайлд хадгалах мэдээллийн хэмжээнээс шалтгаалж хувьсана)
- 120 Gb болон түүнээс дээш хэмжээтэй хатуу диск;
- 15 инч болон түүнээс дээш хэмжээтэй дэлгэц;
- Стандарт гар болон хулгана;
- Microsoft Windows XP болон түүнээс хойших үеийн Microsoft-ийн үйлдлийн систем;
- Mozilla Firefox 5.0 болон түүнээс хойших хувилбарын интернет хөтөч;
- Visual C++ redistribution package.

Ажлын байрны шаардлага:

- Харилцагчийг хүлээн авч үйлчлэх байрыг брокероос бусад ажиллагсдын албан өрөөнөөс тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байх;
- Ажилтны тоонд тохирсон шаардлага хангахуйц албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмж, компьютер, хэвлэгч, хувилагч, бичлэг хийх боломжтой утас, факсын аппаратаар хангагдсан байх.

Дотоодын хөгжүүлсэн системтэй бол:

№	Техникийн төрөл	Техникийн тодорхойлолт
1	Биржийн арилжааны системд холбогдох протокол	FIX протокол (хувилбар 5.0)
2	Системд холбогдсон сүлжээний хугацааны хоцрогдол	Сервер хооронд хугацааны дундаж хоцрол 15 миллисекундээс ихгүй
3	Биржийн арилжааны системд холбогдох Серверийн техникийн үзүүлэлт	CPU 8 цөмтэй Intel Xeon түүнтэй дүйцэхүйц эсвэл дээш
4		RAM 32GB эсвэл дээш
5		Өгөгдөл хадгалах диск SSD байх эсвэл унших хурд 500 MB/s, бичих хурд 500 MB/s ба дээш
6	Сүлжээний орчны аюулгүй байдал ба Галт хана	Дотоод сүлжээний орчин нь галт ханын хамгаалалттай байх
7	Сүлжээний зурвасын үзүүлэлт	Багадаа 1 Gbps хурд
8		Мэдээллийг бодит хугацаанд харуулах тохиолдолд багадаа 10 Gbps
9	Өгөгдөл хадгалах	Системийн өгөгдлийг аюул осол тохиолдох эрсдэлээс үүдэн нөөцөлдөг байх
10	Тестийн орчин	Өөрсдийн гэсэн тестийн орчинтой байх. Ачааллын тестийг хийж гүйцэтгэдэг байх. Тестийн орчин дахь өгөгдөл бодит системээс ялгаатай байх
11	Лог бичилт	Системийн логийг үйлдэл бүрийн хандалт, алдаа, зөрчил зэргээр ялан харуулдаг байх. Файл байдлаар хадгалагддаг байх
12	Өгөгдөл архивлалт	Арилжааны өгөгдлийг устгахгүй хадгалах бодлого, зохицуулалттай байх

---оо---

“Гишүүнчлэлийн журам”-ын
Хавсралт 4

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

д/д	Үйлчилгээний хөлсний төрөл	Үнийн дүн	Төлбөрийн нөхцөл	Төлөх хугацаа
1	<i>Гишүүнээр элсэх өргөдөл гаргахад төлөх үйлчилгээний хөлс</i>			
1.1.	Гишүүнээр элсэх өргөдлийг хянан шийдвэрлэх үйлчилгээний хөлс	500,000 төгрөг	Буцаан олгогдохгүй	Өргөдөл гаргах үедээ
1.2.	Гишүүнчлэлийн элсэлтийн хөлс	15,000,000 төгрөг	Нэг удаа төлнө	Шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор
2	<i>Гишүүнээр элссэний дараа тогтмол төлөх үйлчилгээний хөлс</i>			
2.1.	Гишүүнчлэлийн хөлс	375 000 төгрөг (улирал тутам)	Брокер, дилерийн тус тусдаа болон хосолсон эрхтэй бол	Улирал бүрийн эхний 10 хоногт багтаан төлнө.
2.2.	Гишүүнчлэлийн хөлс	500 000 төгрөг (улирал тутам)	Брокер, дилер, андеррайтерийн эрхтэй бол	
2.3.	Арилжааны системд нэвтрэх эрх ашигласны хөлс	195 000 төгрөг (улирал тутам)	Арилжааны системд нэвтрэх нэг эрх	

---о0о---

**ДОТООД МЭДЭЭЛЭЛ ЭЗЭМШИГЧ БОЛОН ТҮҮНД ХАМААРАЛТАЙ
ЭТГЭЭДИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Дотоод мэдээлэл эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

Үнэт цаасны дансны дугаар

№	Таны болон танд хамааралтай этгээдийн овог нэр, оноосон нэр	Таны юу болох	Регистр	Үнэт цаасны дансны дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Тэмдэглэл
1						
2						
3						
4						
5						

- “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 78 дугаар зүйл, СЗХ-ны “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-ын 4.1 дэх заалтыг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.
- Дансны дугаарт өөрчлөлт орсон, нэмэгдсэн тохиолдолд та мэдээллэх шинэчлэн ирүүлнэ.
- Энэхүү бүртгэлийг хүлээн авсан алба, мэргэжилтэн нууцыг хамгаалах үүргийг хуулийн өмнө хүлээнэ.

Асуултад үнэн зөв хариулсан YЦК / ХК-ийн
...../албан тушаал/

ГАРЫН ҮСЭГ / /
20... оны ... сарын ... -ний өдөр

---00---

АНХАН ШАТНЫ БАРИМТ БҮРДҮҮЛЭЛТИЙН БАТАЛГАА

Үнэт цаасны компанийн нэр:

Хамрах хугацаа:

1. Манай компани нь дээрх хамрах хугацаанд захиалгыг брокероор дамжуулан хүлээн авч, анхан шатны баримтыг үнэн зөв, нотлох баримтын шаардлага хангахуйц хэлбэрээр бүрдүүлсэн болно.
2. Харилцагчаас өгсөн нөхцөлийн дагуу захиалгыг арилжааны системд оруулсан бөгөөд захиалгын нөхцөлд өөрчлөлт оруулсан, анхан шатны баримтыг буруу, дутуу хөтөлсөн, хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээхийг БАТАЛЖ байна.

Баталгаа гаргасан:

Дотоод хяналтын ажилтан /..... /

20... оны ... сарын ... -ний өдөр

---оо---